**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 23 өдөр Дугаар А/434 Мандалговь

Аймгийн Онцгой комиссын Шуурхай
штабыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 зүйлийн $27^1$.1.4, $27^1$.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.5, 32.1.8, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 58 дугаар тушаалаар батлагдсан "Улсын Онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын ажиллах журам"-ын 1 дүгээр бүлгийн 1.3, аймгийн Онцгой комиссын 2021 оны 67 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Тус аймгийн хэмжээнд гамшиг, осол, коронавируст (КОВИД-19)-ын халдвартай тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах зорилгоор аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг шинэчлэн байгуулж удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар, Опертив жижүүрийн шуурхай бүлгийн бүтцийг гуравдугаар, ажиллах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, бүх шатны нутгийн захиргааны байгууллагуудыг үүрэг чиглэлээр хангаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын дарга бөгөөд Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210633